

Монгол нэр	ХОРИН НАЙМАН ОД Санскрит нэр	Төвд нэр
1. Гоё хүүхэн	Барани	Бранэ
2. 6 эхтэй хүү	Гирдиг	Мэндүг
3. Чөлөөт эх	Ровагини	Нарма
4. Гөрөөсөн толгой	Мэргэшир	Го
5. Хэрцгий охин	Артир	Лаг
6. Өглөгт охин	Бурнаवासан	Навсо
7. Найралт эх	Бүс	Жал
8. Үнэг	Аслис	Гаг
9. Их морь	Мэг	Чү
10. Бага морь	Бурвабэлгүни	Дэ
11. Харцага	Удирабэлгүни	Бо
12. Түүхчин	Хасда	Мэши
13. Тэргүүн дагуул	Цэдэр	Нагва
14. Салхины эх	Сувади	Сарий
15. Эрхтийн тэнгэр	Шошаг	Сага
16. Гар од	Анурад	Лхамцам
17. Хонгорцог	Цэсда	Нрон
18. Онгоц	Мол	Нрүв
19. Суулга	Бурвасад	Чүдод
20. Элдэв тэнгэртэн	Ударасад	Чүмад
21. Яруу эгшигт	Аоизи	Дошин
22. Булаагч	Ширван	Жишин
23. Тооно	Даниста	Мондэ
24. Чөдөр	Садабис	Мондү
25. Шувуун хушуут	Бурвабадрабад	Түмдод
26. Могойг хүлэгч	Ударабадрабад	Түммад
27. Дэлгэрүүлэгч	Ривади	Намдү
28. Шийдэм	Ашувани	Тагар

**МОНГОЛЫН
УЛАМЖЛАЛТ
АНАГААХ УХААН**

Б. Болдсайхан

Эртний түүхийн сурвалж бичиг дэх Монгол нутагт оршин тогтнож байсан аймаг угсаатны анагаах арга заслын тухай зарим баримт сэлтээс Монголчууд эрт дээр цагаас ардын эмнэлгийн зохих мэдлэгтэй байсныг олж мэдэж болох юм.

МЭӨ Ш—П зууны үед БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр оршин тогтнож байсан Хүннү улсын үед төөнө тавих эмчилгээг анх түрүү бий болгон түүнийг Хятадууд авч хэрэглэсэн тухай МЭӨ П зууны орчим бичигдсэн эртний хятадын анагаах ухааны «Нэй зин» номонд дурьдсан тухай мэдээ бий.¹

Хүннү нарт оточ байсан талаар ном зохиолд тэмдэглэснээс үзвэл: «МЭӨ 100 оны орчим хүннүгийн оточ хятадын элч Су у-г шархдахад тусламж үзүүлсэн...» тухай өгүүлсэн байдаг.² Хээр шархадсан хүнийг оточ нарт яаралтай хүргэхдээ: «Хүннү нар МЭӨ 129 онд шархадсан хүнийг хоёр морьтон хоорондоо суран тор татан дээр нь хэвтүүлээд зөөвөрлөдөг байжээ.»³

Хүннү нарын дараа оршин тогтнож байсан Сяньбийн үеийн оточ нарт «Өвдөж зовбол агь шатааж утах, чулуу халааж төөнөх, бас халаасан газар дээр жигнэн хэвтүүлж, өвчилсөн эрхтнийг ханаж цус гаргах зэргийн эмчлэх-домнох арга байжээ.»⁴

Уйгарууд МЭ I зууны үед Хүннүгийн захиргаанд байгаад сүүлдээ Монгол нутаг дээр уйгарын хаант улсыг байгуулан тогтнож байсан VIII - IX зууны үед анагаах ухааны мэдлэг нэлээд хөгжиж байжээ. Өмнөх үеийн нүүдэлчдээс уйгаруудын өвлөн авсан ардын эмнэлгийн уламжлал нь тухайн үедээ улам өргөн дэлгэрч баяжин хөгжсөнөөр бусад улсад ч зохих нөлөө үзүүлсэн тухай мэдээ бий. Тухайлбал уйгарын анагаах ухааны эрдэмтэн Сада-Мини гэдэг хүн «руй жуй тан» гэдэг нэртэй эмийн сангийн туршлагат жор» зохиожээ. Энэ жор нь уйгараас Хятад зэрэг оронд нэвтрэн дэлгэрчээ.⁵

Уйгарууд нь эм тан, үнэртний зүйлийг...гадагш гарган худалддаг байсан» гэж түүхэнд тэмдэглэсэн байна.⁶ Тухайлбал: бор өнгийн эвэр, наосао (шивтэр), далайн баавгайн чих, бөөр, алмаз, улаан давс, хаш аэрэг зүйлийг Хятадад гарган худалдаж,⁷ эдгээр зүйлс орсон эм хийж байсан аж.

XIII зууны үед монголчууд шархдагсдын цусыг нь сорох, шархыг нь хайран анагааж байв.⁸ Түүнчлэн шархадсан хүмүүсийг дөнгөж сая алсан хонь, ямаа, үхрийн арьс ширээр боож, ороох шархыг хайрч төөнөх, хөл гарын өвчтэй хүмүүсийн хөл гарыг хонь, ямаа зэрэг малын бүлээн сэвсээр жин тавих зэргээр эмчилж байжээ.⁹

Монгол оточ нар эмийн ургамал, жимсний үр нөлөө, тэдгээрийн ургах газар, ургамлын ашигтай нөлөөтэй хэсгийг түүх, эм хийх аргыг сайтар мэддэг байв. Монгол хүн морин дэл дээр өсч бойжин ан хомрого, дайн байлдаанд бэртэж шархдах нь олонтоо байснаас эрт дээр цагаас гэмтэл бэртэлд үзүүлэх тусламж нь баяжин хуримтлагдаж байсан нь тодорхой юм. Тархи доргих, цуллаг эрхтэн доргих зэргийг доргион засах арга, нүд бүлтрэх, мөр мултрах, мэсийн шархыг эмчлэх, яс зүйх, барьж эвлүүлэн боох, төөнө тавих, ханах зэрэг нь, зөвхөн нүүдэлчдээс тухайлан хэлбэл монголчуудаас гаралтай эмчлэх аргууд юм. Тэдгээр арга заслын зарим нь бусад улс үндэстэнд нэвтрэн тархсан тухай баримтууд тэмдэглэгдсэн байдаг. Тухайлбал: «Монгол үндэстэн анагаах ухааны талаар төвд эмнэлгээс гадна янз бүрийн шарх, ясны бэртэнгийг эмчлэх талаар алдартай сайн байсан бөгөөд энэхүү онцгой эмчлэх арга нь XVII зууны үед хятадад нэвтэрчээ»¹⁰ гэж дурьдсан байдаг.

Монголчуудын олон зуун жил хуримтлуулсан аливаа өвчин эмгэгтэй тэмцэх арга туршлага нь эхэн үедээ нэгдсэн системгүй ардын эмнэлгийн шинжтэй байжээ. Ардын эмнэлгийн арга туршлага нь гол төлөв ам дамжин уламжилж байснаас тэдгээрийг нэгтгэн бичиж тэмдэглэсэн материал тун ховор юм.

Ардын эмнэлгийн уламжлал нь нэлээд хожуу үед хар домын судар хэлбэрээр бичигдэн үлдсэн материалууд цөөнгүй байдаг. Эдгээр материалыг шүүрдэн үзэхэд өвчнийг ямар ч системгүйгээр шинж тэмдгээр нь алаг цоог бичиж, дарах, засах арга хэлбэрийг домнох төдий дурьдсан байна. Домын судруудыг хооронд нь харьцуулан үзэхэд олонхийн нэр ижил, доторхи арга засалд нь адил төстэй талууд ихтэй

нь эдгээр судрууд нэгэн эх сурвалжтай болохыг харуулж байгаа юм. Уламжлалт эмнэлгийн ном судраас домын судрын ялгаа нь зохиосон тодорхой эзэнгүй, бага хэмжээний хэсэг бусаг түүвэр хэлбэрээр монгол хэлээр бичсэнээс гадна өвчний нэрийг илрэх шинж тэмдгийн нэр төдий дурьдсан, эмчлэн засахдаа голдуу ганц бүтэцтэй эмт бодисуудыг заасан байна. Эдгээр эмт бодисуудыг олж ашиглахад хялбар талыг харгалзан үзсэн тал ажиглагдана. Домын зарим судраас энд сонирхуулан дурьдвал: «Домын гол эмнэлгийн судар» гэдэг жижиг хэмжээний сударт «Туулай, үнэг, багваахай, хөх үхэр, цагаан морины биед байх эмийг өгүүлэх нь» гэсэн хэсэг бүлэг бий. Жишээ нь «туулайн бие дэх эмийг үзүүлэх нь» гэсэн хэсэгт туулайн мах хүйтэн чанартай. Толгой өвдөх, үндсэн тамир тасарваас махыг идвэл эм... гэх зэргээр тоочин дурджээ. Мөн тод үсгээр бичигдсэн «хөх хуцын дом» гэдэг 9 хуудастай сударт хөх хуцын бие дэх эмийн чанарын талаар нэлээд зүйл орсон байна. Үүний зэрэгцээгээр эмийн чанараас гадна хортой зүйл байгааг «Хөх хуцын зүрхэн дотор нүх бий. Тэр их хортой тул бүү ид» гэж анхааруулсан тал ч байна.

Домын судруудын дотор аливаа хурц чанартай өвчинд түргэн туслах хялбар арга заслуудыг нэгтгэн өгсөн ганц нэг судрууд ч байдаг. Энэ бүхнээс үзвэл Төв Азийн нүүдэлчин улс түмний ахуй амьдралын онцлог байдалд зохицсон олон үндэстний ардын эмнэлгийн арга туршлагыг тухайн үедээ нэгтгэн ашиглаж байсны нэгэн илрэл гэж үзмээр. Учир нь тархай бутархай амьдарч байсан ахуй амьдралын нөхцөлд өөрсдөдөө ашигтай хэрэглэхэд хамгийн амар дөхөм арга заслууд нүүдэлчин ард түмэнд шаардагдаж байсан нь маргаангүй юм.

Анагаах ухааны түүхэн анхны хэлбэр нь ардын эмнэлэг байсан гэж үздэг. Ардын эмнэлэг нь хөдөлмөрийн хуваарьгүй, практик чиглэлтэй, биеэ даасан шинжгүй, үлэмж их эмперик шинжтэй мэдлэг юм.¹¹ Улс үндэстэн бүрт өөрийн гэсэн ардын эмнэлгийн практик уламжлал байдаг. Харин уламжлалт эмнэлэг нь тухайн үүсэн бий болсон үеийнхээ гүн ухааны үндэслэл, онолын үндсэн зарчим дээр тулгуурлан биеэ даасан системийг бүрэлдүүлдэг ажээ. Уламжлан дамжсан улс орны ардын эмнэлгийн практик уламжлалаар цаашид баяжин хөгжиж нэлээд хэдэн улс орны чанартай анагаах ухааны мэдлэгийн цогц ойлголт болж байсан нь дорнодахины анагаах ухааны түүхэн уламжлалаас тодорхой билээ.

МЭӨ III-I зууны үед оршин тогтнож байсан Римийн эзэнт улсын дорнод муж болон Эртний Египет, Месопотами, Энэтхэг, Хятад зэрэг улсуудыг тухайн үеийн Римийн болон хожим үеийн түүх бичлэг «Эртний дорнодахин» гэж тэмдэглэсэн байдаг. Эртний дорно дахины улсуудаас Энэтхэг, Хятадын анагаах ухааныг тухайн үед дорнодахины анагаах ухаан, Дундад Азиас үүссэн анагаах ухааныг өрнө дахины анагаах ухаан гэж нэрлэж байснаас «дорнодахины анагаах ухаан» гэсэн нэршил үүсжээ. Дорнодахины анагаах ухааны үндсэн хэсэг болох Энэтхэг болон Хятадын анагаах ухааны чиглэл нь гүн ухааны үндэслэл, онолын үндсэн зарчмаар хоорондоо ялгарах тус тусын системтэй ажээ. Энэтхэгийн анагаах ухааны системд Балба, Шри-Ланк, Бангладеш, Пакистан, Төвд, Монголын уламжлалт эмнэлэг багтдаг. Эртний энэтхэгийн анагаах ухаан нь МЭӨ VII зууны орчим үүсэж бүрэлдсэн сахъяа чиглэлийн гүн ухааны сургаалын үндсэн дээр энэтхэг ёсны таван махбодын (шороо, ус, гал, хий, огторгуй) үзлийн үндэс суурин дээр анагаах ухааны ойлголт төсөөллөө илэрхийлдэг.

Харин эртний хятадын анагаах ухаанд МЭӨ VIII—V зууны орчим хөгжин боловсорч байсан эртний хятадын гэнэн материалист үзэл урсгалын үндэс суурин дээр хятад ёсны таван махбодын (гал, ус,

шороо, төмөр, мод) үзлийн өөр нэгэн ойлголтоор илэрхийлж байжээ. Энэ нь энэтхэг ёсны таван махбодоос төмөр, мод элементээр ялгагдаж буй нь МЭӨ VI зууны үеэс хятад оронд төмөр зэвсгийн үе эхлэн мод, төмрийг ахуй амьдралдаа өргөнөөр ашиглах болсонтой холбон үзэж болох учиртай. Харин дэлхий дээр хамгийн түрүүнд тухайлбал МЭӨ X зуунаас өмнө төмөр зэвсгийг хэрэглэсэн¹² гэгдэх эртний энэтхэг оронд төмрийн талаар ойлголт аль хэдийнээ бий болсон атлаа авч хэрэглээгүй байдаг нь сонин юм. Үүний нөхцөл шалтгаан нь энэтхэгчүүд эрт дээр цагаас эхлэн ертөнцийн тоо томшгүй юмс үзэгдэл, хүний санаа сэтгэлийн үйл явцыг сэтгэн бясалгахыг эрхэмлэж байхад хятадууд практик ажиглалтын үүднээс гярхай арга ухааныг илүү ихээр эрэлхийлж эрхэмлэж байсан нь тухайн хоёр орны ард түмний аж байдлын онцлог талаас урган гарав уу гэлтэй. Энэтхэгчүүд ухаан бодлоо төвлөрүүлэхийг ихэд үнэлэн ёгийн дасгал сургуулилтаар биеийн дотоод хүч энергийг зохицуулан тэнцвэржүүлснээр бие сэтгэхүйн эрүүл саруул байдлыг бататган чийрэгжүүлэх, аливаа өвчин эмгэгийг анагаан засах үндэс болгодог. Харин хятадууд металл зүүний туслал цаатайгаар биеийн тодорхой сүв судлуудад жор зааврын дагуу хатган, биеийн дотоод хүч энергийг үүсгэж эмчлэх аргыг бий болгожээ. Энэ нь ёгийн дасгалтай харьцуулахад эмчилгээ заслын амар хялбар арга болох нь тодорхой. Ийнхүү Энэтхэг, Хятад эмнэлгийн эмчилгээний арга заслын онцлог нь бие сэтгэхүйн аль нэг тал дээр гол анхаарлаа чиглүүлэн байжээ.

Дорнодахины анагаах ухааны хамгийн анхны нэгэн чиглэл нь эртний Энэтхэг үүсэж бүрэлджээ. Эртний Энэтхэгийн мэдлэг ухааны зарим ойлголтууд домог яриа, аман сурвалжаар дамжин ирснийг анх түрүүнд бичиж тэмдэглэж үлдсэн нь «Вед» нэртэй их шүлэглэлийн цоморлигууд юм. Вед гэдэг нь мэдлэгийн сан гэсэн утгатай санскрит үг ажээ. МЭӨ XII-X зууны орчим «Ригвед» хэмээх анхны вед шашдир гарч¹³, үүнээс арай хожуу «Самавед», «Яджурвед», «Атхарвавед» шашдируудыг бярман лам нар зохиосон гэдэг. «Ригвед», «Атхарвавед» шашдирт анагаах ухааны холбогдолтой нэлээд шүлгүүд орсон нь «Аюурвед» эмнэлгийн ном зохиолууд бие даан гарч ирэхэд чухал нөлөө үзүүлсэн ажээ. Аюурвед гэдэг нь «насны ухаан» гэсэн утгатай санскрит үг ажээ. Аюурвед эмнэлгийн түүхэнд түүний үүсэж хөгжихөд чухал нөлөө үзүүлсэн вед шашдируудын үеийг МЭӨ 1500-800 он хүртэл хугацааг хамруулан үздэг. Дараагийн үе нь МЭӨ VI зуунаас МЭ X зууныг хүртэл аюурвед эмнэлгийн сонгодог бүтээлүүд гарсан үе гэж нэрлэдэг.¹⁴ Аюурвед эмнэлгийн сонгодог зохиолууд болох «Чарака самхит», «Сушрута самхит» нь МЭӨ VII—V зууны үед гарсан гэж энэтхэгийн эрдэмтэд үздэг.¹⁵ Аюурвед эмнэлгийн ном зохиол бүрт дагаж мөрдөх нэгэн зарчим байсан нь өвчнийг найман ангилал тус бүрээр боть зохиол бөлгөн авч үздэгт оршино. Тийм учраас «найман гишүүнт» гэсэн нэрийг сурвалж бичгийн нэрэнд хавсаргах нь олонтоо байдаг. «Чарака самхит», «Сушрута самхит» болон аюурвед эмнэлгийн бусад бүтээлүүдийг нэгтгэн Кашмирын алдарт эмч Вагб хата (Пахаль) МТ II зууны үед «Ашта анга хридая самхита» (найман гишүүнтийн зүрхний хураангуй) гэдэг бүтээлээ туурвижээ. Ваго хатын бүтээлүүдэд нэлээд хожуу Кашмирын хоёр дахь нэртэй эмч Чандранидана (Дава Онго) «Тикка-чандра кара» (тайлбар сарны гэрэл) гэдэг нэртэй нэмэлт тайлбар бичжээ. Энэ ном хожим Дэргэ барын данжуурын 198 дахь боть болон төвд хэлээр орчуулагджээ. Уг ном нь гурван боть бүгд 940 хуудастай томоохон бүтээл юм. Вагбхата Чандранидана нарын бүтээлүүдийг өмнөх үеийн ном сурвалжийг

улам боловсронгуй болгосон аюурвед эмнэлгийн хамгийн сүүлийн нэр цуутай бүтээлүүд хэмээн үздэг.

Төвдийн их орчуулагч Бирузана МТ VIII зууны үед энэтхэгээс Чандрананданы «Дөрвөн үндэс» түүний тайлбарыг анх төвд хэлэнд орчуулжээ. Их Ютиг Ёндонгомбо (708-833) Кашмирын алдарт эмч нар болох Вагбхата, Чандранандана нарын ном түүнд Бирузаны хийсэн төвд орчуулга зэргийг хянан үзэж нэлээд цэгцлэн зарим нэмэлт хэсгийг оруулжээ. Төвдөд олон үе дамжсан удам судраараа сайн эмч нар байсныг ном сударт Ютиг нэртэй нэгэн овогт хамруулан дурьдсан байдаг. Тэдний гарал үүслийг Кашмирын алдарт эмч нарын үеэс эхэлнэ гэдэг. Ютиг гэдэг нэр нь «Оюу дээвэрт» гэсэн үг бөгөөд чухам яагаад ийнхүү нэрлэсэн талаар сонин домгийг Ютиг Ёндонгомбын намтарт өгүүлжээ. Ютиг овогтны XIII үе болох бага Ютиг Ёндонгомбо «Дөрвөн үндэс» номыг нутаг орныхоо байдалд тохируулан, ойлгоход хялбар болгон зарим нэмэлтийг оруулан XI зууны үед зохиосон болох нь зарим иш баримт сурвалжаас тодорхой юм. Уг номын ерөнхий агуулга, бүлэг зэрэг нь Вагбхатын номтой бараг ижил боловч түүнээс ялгагдах зарим онцлог байдаг. Үүнд: Тэргүүн ботид номын бүх ерөнхий утгыг багтаан бичиж, суралцахад хялбар болгосноороо бусад ботиудынхаа «Зава» ном нь болдог. Энэтхэг төвдийн уламжлалт ёсоор цээжлэхэд зориулан шүлэглэсэн хэлбэрээр бичсэнийг төвдөөр зава (санскритаар мула) гэх бөгөөд үг утга бүрийг тайлбаргүйгээр ухаж ойлгоход хэцүү ажээ. Хоёрдугаар ботид: Эм, идээ ундааны бүлэгт зарим өөрчлөлт нэмэлт хийжээ. Гуравдугаар ботид зарим бүлгийн утга агуулгыг ойлгомжтой болгон тайлбарласан ажээ. Дөрөвдүгээр ботид хятад эмнэлгийн «Сомараз» болон анагаах ухааны бусад бүтээлүүдээс шээс шинжлэх, судас барих, хатгуур, монгол төөнө зэрэг биеийн заслын талаар нэмэлт бүлгийг оруулжээ. Энэ ном «Жүд ши» (Дөрвөн үндэс) буюу «Дүзэ нинбу янлаг жадва санман ман аг жүд» (Рашааны зүрхний найман гишүүнт нууц увдисын үндэс) гэсэн нэрээр алдаршжээ. «Дөрвөн үндэс» ном нь Төв Азийн нүүдэлчин улс түмний ардын эмнэлгийн практик туршлагыг тодорхой хэмжээгээр нэгтгэн өмнөх үеийн ном сурвалжийн уламжлалыг нутаг орны байгаль цаг уурын байдалд зохицуулан туурвисан бүтээл юм. «Дөрвөн үндэс» ном нь тухайн үедээ анагаах заслыг товч тодорхой өгүүлснээрээ эмч нарын суралцахад дөхөмтэй хамгийн гол гарын авлага болж байжээ. Энэ зохиол XVI зуун хүртэл нэлээд оронд эмч нарыг бэлтгэхэд ашиглагдаж байсан цорын ганц ном бөгөөд нэр цууд их гарчээ.¹⁶ «Дөрвөн үндэс» номонд XV зуунаас төвд эмч нар нэмэлт тайлбарын хийсэн бүтээлүүд олноор гарч ирсэн байна. «Дөрвөн үндэс» гэж нэрлэсэн нь учир холбогдолтой болохыг төвдийн эрдэмтэн Дэсрэд Санжажамц «Бидэр онбо» гэдэг уг номын тайлбар зохиолдоо: МТӨ 961 онд шигемуны сургаал гарсан (сакъяа муни-сакъяагийн мэргэн чадагч), МТӨ 890 онд эх үндэс нь зохиогдсон, МТ 747 онд Лозава Бирузана «Дөрвөн үндэс»-ийг орчуулж төвдөд авчирсан гурван тэмдэглэлт үеийг дурсан тайлбар зохиолоо бичсэн гэжээ. Энэ нь аюурвед эмнэлгийн гүн ухааны үндэс болсон «сакъяа» сургаал гарсан, түүнээс эх үндсээ авсан дөрвөн үндэс зохиогдож, анагаах ухааны дөрвөн үндэс нь төвдөд дэлгэрсэн зэрэг уламжлалт уялдаа холбоо байгааг энэхүү баримтаар илэрхийлжээ. «Рашааны зүрхний найман гишүүнт нууц увдисын үндэс» гэсэн уг номын нэрийн утгыг монголын нэрт оточ Лүнрэг Дандар «Эмийн дөрвөн үндэсний зарим дохионы утгыг тайлсан намжал арүрийн эрхэсийн үзэсгэлэнт чимэг» зохиолдоо: Цаг бусын үхлээс авардаг учир «рашаан», өвчин бүгдийг дарж чадах учир «зүрх», өвчнийг найман гол ангиллаар хуваадаг учир «найман гишүүнт»,

мөхөс ухаантанд сав болж чадахгүй тул «нууц», үйлдэхэд хялбар, үг нь цөөн, утга их, жишихэд бэрх учраас «увдис », Энэтхэгийн эмнэлгээс үндэслэсэн учир «үндэс» гэсэн юм гэжээ. Энэхүү ном нь за жүд (язгуур үндэс), ша жүд (онолын үндэс), ман аг жүд (увдисын үндэс), чима жүд (шинжлэл заслын үндэс) гэсэн дөрвөн боть ажээ.

XV—XVШ зууны үед төвд эмч нар анагаах ухааны «Дөрвөн үндэс» номыг тайлбарлах, түүнийг улам баяжуулан нэмэлт засварыг хийх, эмт бодисын үйлчлэлийг улам өргөн дэлгэр авч үзэх, биеийн заслын аргуудын онолын үндсэн зарчмыг тодруулан тайлбарлах зэрэг бусад олон тайлбар дүгнэлт хийсэн нэр цуутай олон зохиол бүтээлээрээ уламжлалт эмнэлгийн сан хөмрөгийг баяжуулж байжээ. Монгол ардын эмнэлгийн олон зуун жил хуримтлуулсан практик туршлага нь Энэтхэг-Төвдийн уламжлалт эмнэлгийг цаашид хөгжүүлэхэд багагүй үүрэг гүйцэтгэжээ. Энэтхэгээс төвдөд уламжлан ирсэн эртний анагаах ухааны сурвалж бичгүүдийг төвд эмч нар улам баяжуулан хөгжүүлснийг монголчууд өөрсдийн зохих хувь нэмрийг оруулснаар Монголын уламжлалт анагаах ухааны ном судрын баялаг сан хөмрөгтэй болжээ. XIV зуунаас XX зуун хүртэл монголчуудын зохиож бүтээсэн уламжлалт анагаах ухааны ном зохиолууд олон арваараа бий. Тухайлбал Монголын ууган оточ Данзанжанцангийн (XVI) «Анагаах ухааны язгуур үндэсний тайлбар тодорхой зул», «Өвчний ялгалыг сайтар өгүүлж тодорхойлсон нь», Сүмбэ ханба Ишбалжирын (XVШ) «Дөрвөн рашаан», «Эмийн нэр ба эмт бодисыг таних болор толь», Лувсан ванжилын (XVI) «Нэмсэн аргын зуулт тайлбар», Лувсанчүл тэмийн (XVI—XIX) «Эм таних ухаан», «Жамбалын (XVII—XI) «Увдисын далай», Жамбалдоржийн (XIX) «Нүдний үзэсгэлэнт чимэг», Чоймболын (XIX) «Түүвэрлэн хураасан зүрхний чандмань», Ишдан занванжилын (XIX—XX) «Шүрэн унжлага». Ёндонгийн (XIX—XX) «Цогт дөрвөн үндэсний түүвэр нэр нүүр царайг тодорхойлогч толь», Дандарын (XIX—XX) «Эмийн дөрвөн үндэсний зарим дохионы утгыг тайлсан намжил арүрийн эрхэсийн үзэсгэлэнт чимэг», Чойжамцын (XIX—XX) «Гайхамшигт баясгалант хуримын сан» гэх зэрэг нэртэй бүтээлүүдийн заримаас дурьдаж болох юм. Монгол оточ Жамбалдорж «Нүдний үзэсгэлэнт чимэг» номондоо: Эрдэнэ, эрдэс чулуу, минераль, ургамал, амьтны гаралтай 849 эмт бодисыг тодорхойлон бичжээ. Уг номонд эмт бодисын нэрийг санскрит, төвд, хятад, манж, монгол бичгээр хадаж 576 зургийг хамт дагалдуулсан байна. Энэ бүхнээс үзэхэд монголчууд өөрсдийн ардын эмнэлгийн практик туршлагын үндэс суурин дээр Энэтхэг болон төвдөд уламжлан ирсэн дорнод ахины анагаах ухааны нэгэн гол чиглэлийг улам боловсронгуй болгож хөгжүүлэхэд тухайн үедээ багагүй нэмэр хандивыг оруулж байсны нэгэн илрэл юм.


Монгол ардын уламжлалт эмнэлэг нь дорно дахины анагаах ухааны хоёр гол чиглэл болох энэтхэг болон хятадын анагаах ухааны онолын үндэслэл, практик туршлагыг үндэслэн монгол ардын эмнэлгийн баялаг туршлагаар баяжуулан өгснөөрөө онцлог талтай юм. Монгол ардын уламжлалт эмнэлэг нь биеийн бүтэц зүй, өвчин эмгэг түүнийг эмчлэх эмт бодисын үйлчлэл, бие сэтгэхүйн ёг дасгалуудын дэг зарчмыг энэтхэг ёсны таван махбодын үзлийн үндэс суурин дээр тайлбарладаг. Үүгээрээ хүний мэдрэхүйн үйлд шууд тусахааргүй биеийн бүтэц үйл ажиллагааны нарийн нийлмэл зохицоо холбоог хийсвэрлэн загварчилж ухаарч байжээ. Үүний зэрэгцээгээр судас барих, хатгуур, төөнө, хануур болон таван цул (зүрх, уушиг, элэг, бөөр, дэлүү), зургаан сав (ходоод, гэдэс, олгой, давсаг, цөсний уут, үржлийн эрхтэн (эрхтний хоорондын уялдаа холбоо тэдгээрийн махбодид гүйцэтгэх

үүрэг ажиллагаа, улирал цаг хугацааны үечлэлийг хятад ёсны хар зурхайн таван махбодын үзлийн үндэс суурин дээр тайлбарлаж байжээ. Ийнхүү монгол ардын уламжлалт эмнэлэг дорно дахины анагаах ухааны энэтхэг болон хятад эмнэлгийн онолын үзэл сургаалыг нэгтгэн өгч хүний биеийн үйл ажиллагааг тал бүрээс нь авч үзэх үзэл санаа тухайн үедээ бүрэлдэж байсан нь нэн сонин юм. Энэхүү онол сургаалаас үүдэн хүний бие дотоод үйл ажиллагааг тэнцвэртэй байдалд байлгах үндэслэлийг гаргаж байжээ. Энэтхэг ёсны таван махбодын үзлийн үндсэн дээр сэтгэхүйн үйл ажиллагааны тэнцвэрт байдлыг тайлбарлан авч үзсэн байдаг. Эмийн сударт таван хорыг (уур, харам, тачаал, атаа, мунхаг) тэвчих нь хүний сэтгэл санаатай холбоотой хэмээн дурьдаад эдгээр сэтгэл хөдлөлийг захирч жолоодоход тэвчиж тэнцвэржүүлж сурахыг оролдсон сэтгэхүйн ёг дасгал гарч ирсэн байна. Энэхүү уламжлалыг монголчууд XVIII зууны үед энэтхэг болон төвдөд бүтээгдсэн өмнөх үеийн ном судрыг нэгтгэн дүгнэж нэлээд өндөр түвшинд хөгжүүлж байжээ.

Хятад ёсны таван махбодын үзлийн үндсэн дээр биеийн үйл ажиллагааны тэнцвэрт байдлыг тайлбарлан авч үзсэн байдаг. Эмийн сударт хүйтэн чанартай өвчнийг төөнөх, халуун чанартай өвчнийг ханаж цус авах, зүү тавьж өвчилсөн хямралыг тэнцвэржүүлэх эмчилгээг хийх талаар тодорхой дурьдсан байна. Мөн цул сав эрхтэний үйл ажиллагааны идэвхжил, буурлыг тухайн жилтэй харьцуулан тооцоо бодох загварчлалын үндсэн дээр тухайн хүний бие махбодын хямрал өөрчлөлт, түүний шалтгаан, нөхцөл түүнд тохирох эмийн жор найрлагыг нэгэн зэрэг илэрхийлэх тооцооллыг Монголын мэргэд боловсруулж байсан ажээ. Уламжлалт эмнэлгийн онолын үндсэн зарчимд хүний өвчин эмгэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд сэтгэл заслын асуудлыг нэлээд хөндөж дурьдсан байдгаар барахгүй уураг тархины нөөц чадварыг шавхан дайчлах сэтгэхүйн дасгал сургуулилтын тодорхой системийг боловсруулан байсан нь тухайн үедээ уламжлалт эмнэлгийн онолын гол хэсэг нь болж байсныг энд тэмдэглэх нь зүйтэй юм. Тийм ч учраас таван махбод, арга билиг, хоосон чанар гэсэн сэтгэхүйн соёлын уламжлалт зарим ойлголтуудын логик уялдаа холбоо нь энэхүү хэсэгт гүнзгийрч тусгалаа олсон байна. Ирэх зууныг эрдэмтэд «сэтгэлзүйн зуун» болно хэмээн дүгнэн тэмдэглэсэн байдаг. Хүний уураг тархи түүний шавхагдашгүй нөөц чадварыг нээн илрүүлэх явдал мөнхүү түүнд хамаарах нь дамжиггүй билээ. Энэ талаар хуримтлуулсан олон зуун жилийн практик уламжлал, сэтгэхүйн ёг сургуулилтын бүхэл бүтэн системийг монгол зохиогчид нэгтгэн дүгнэсэн ном зохиолууд цөөнгүй байжээ. Одоо үед дорнодахины анагаах ухааны практик уламжлал судлаачдын анхаарлыг татах болж буй шиг түүний онол номлолын учир уялдааг агуулсан сэтгэхүйн соёлын энэхүү уламжлалт ойлголт судлаачдын анхаарлыг улам ихээр татах бизээ.

Ард түмний хөгжүүлж ирсэн өмнөх үеийн соёлын өв санг нягтлан судлаж, түүний дэвшилтэт үр шимийг сорчлон авах нь хөгжлийн диалектик зүй тогтлоос урган гардаг билээ. Энэхүү өв сангийн нэгээхэн хэсэгт Монголын уламжлалт анагаах ухаан түүний онол номлолын учир уялдааг цогцлон агуулсан сэтгэхүйн ёг сургуулналын ном судрын элбэг баян сан хөмрэг зүй ёсоор орно. Бид энэхүү сан хөмрөгийг нэлээд гүнзгийрүүлэн нарийвчлан авч үзсэнээр буддизм нэрийн дор хөгжин боловсорч байсан эрт үеийн соёл, мэдлэг ухаануудын та лаархи ойлголт төсөөллүүдийг шашны бүрхүүл халхавчаас ялган салгаж, ашигтай үр шимийг шинжлэх ухааны үндэстэй судлан ашиглах боломж багагүй бий билээ. Энэхүү зорилгыг биелүүлэхэд тухайн үеийн

мэдлэг ухаануудын (дуун ухаан, учир шалтгааны ухаан, анагаах ухаан, урлахуй ухаан, дотоод ухаан) ном сурвалжийн хоорондын уялдаа холбоог философи, хэл шинжлэл, түүх болон байгалийн ухааны үүднээс авцалдаа холбоог харгалзан үзэх нь дорно дахины ард түмний олон зуун жилийн турш хуримтлуулсан практик уламжлал, хүн байгалийн уялдаа холбоо, аливаа өвчин эмгэгтэй хэрхэн тэмцлийг явуулж байсан хийгээд хүний дотоод нөөц чадварын талаар хуримтлуулсан багагүй туршлагыг нэгдмэл байдлаар нь авч үзэхэд чухал ач холбогдолтой юм.



¹ Монгол анагаах ухааны эрдэм шинжилгээний өгүүллийн түүвэр, Өвөр Монгол хэвлэл, 1983, 527-р тал

² Материалы по истории Сюнну (по китайским источникам) Предисловие, перевод и примечания. В. С. Таскина. М., 1968, 102-р тал

³ Мөн тэнд 103-р тал

⁴ БНМАУ-ын түүх. Гурван боть, Тэргүүн боть, нэн эртнээс XVШ зуун. УБ., 1966, 108-р тал

⁵ Чжунго гудайши чанши, Бэйцзин., 1979, 354-р тал

⁶ Бичурин. Н. Я., Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в Древние времена, Л—М., 1950, 218-р тал

⁷ Вэй у эр цзушиляо цзянь бянь, Т-1, Бэйцзин., 1981, 64-р тал

⁸ Рашид-Ад-Дин Сборник летописей. Изд. Акад. Наук СССР, 1952, том I. М-Л, 1952, 169-р тал

⁹ 4-ийн 398-р тал

¹⁰ Чжунго шаошу Миньцзу, Бэйцзин, 1981, 73-р тал

¹¹ Щепин О. П., Царсгородцев Г. И., Ерокин В. Г, Медицина и общество, М.. 1983, 27-р тал

¹² Бонгард-Левин Г. М., Ильин Г.Ф., Индия в древности. М., 1985, 127-р тал

¹³ Мөн тэнд 172-р тал

¹⁴ Udupa K. N. Singh. Science and Philosophy of Indian Medicine. Nagpur. , 1978. p. II

¹⁵ Bhagwan Dash V. Fundamentals of Ayurvedic Medicine. Bansal & Co., 1978. P 10

¹⁶ Хайдав Ц. Дорнодахины анагаах ухааны судар бичгийн тойм, УБ., 1975, 45-р тал